



БАТЛАВ:
ЧОЙБАЛСАН СУМЫН
ЗАСАГ ДАРГА Г.ТӨРБОЛД

ДОРНОД АЙМГИЙН ЧОЙБАЛСАН СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ГАДНАХ ТОГЛООМЫН ТАЛБАЙГ ТОХИЖУУЛАХ ТӨСӨЛ

2022.12.08

- 1.Төслийн нэр: “Намайг хараарай. Би том болж байна.”
- 2.Төслийн үйл ажиллагаа: Цэцэрлэгийн гадаа талбайн тоглоомын хэрэглэгдэхүүний тоог нэмэгдүүлэх
- 3.Төсөл бичсэн огноо: 2022.12.08.
- 4.Төсөл эхлэх хугацаа: 2023
- 5.Төсөл дуусах хугацаа : Цаашид хүүхдийн эрүүл мэнд , бие бялдар, оюун ухааны хөгжил, төлөвшлийн үйл ажиллагаанд байнга хэрэглэнэ.
- 6.Төсөл хэрэгжүүлэгч : Багш ажилчид, эцэг эх
- 7.Төсөл бичсэн : Цэцэрлэгийн хамт олон
- 8.Төслийн хэлбэр: Шинэ
- 9.Төсөв : 500000

Төслийн хэрэгцээ шаардлага буюу үндэслэл

Тус сумын цэцэрлэг нь 1965 онд байгуулагдан 1990 онд өргөжин тэлж 100 хүүхэд хүлээн авах зориулалтын байр шинээр ашиглалтанд орсон. Мөн 2022-2023 оны хичээлийн жилд 4 бүлэг, 118 хүүхэд хүлээн авч хамран сургалтаа 86%-д хүргэн 21 багш ажилчидтай үйл ажиллагаагаа явуулж байна.

СӨБ –ийн чанарын шинэчлэлийг хэрэгжүүлэх, боловсролын салбарт тавигдаж байгаа орчны стандартдад нийцсэн орчин бүрдүүлэх, бага насны хүүхдийг тоглоомоор дамжуулан хөгжүүлэх тэднийг эрүүл чийрэг бие бялдар,зөв хөгжил төлөвшилтэй иргэн болгон хүмүүжүүлэхэд гадна талбайд тоглоомуудыг цогцоор нь бий болгох шаардлага тулгараад байна.

Төслийн зорилго:

- 1.Бага насны хүүхдийн бие бялдрын хөгжил, нас сэтгэхүйн онцлог, хэрэгцээ, шаардлагад нийцсэн биеийн тамирын талбайн сургалтын хэрэглэгдэхүүн, орчин нөхцөлөөр хангах
2. Бага насны хүүхдийн хөгжлийн стандартыг хэрэгжүүлэх
3. Хүүхэд хөгжүүлэх үйл ажиллагааг хүртээмжтэй, чанартай зохион байгуулах, хүүхдийн дунд төрөл бүрийн уралдаан тэмцээн зохион байгуулах орчин бий болгох

Төслийн зорилт

Бага насны хүүхдийн хөгжлийн стандарт хэрэгжилт хангагдаж, сургалтын чанар хүртээмж нэмэгдэнэ.

Сургалтын хэрэглэгдэхүүн тоглоом, наадгай нь эрүүл ахуй , ариун цэврийн шаардлага хангасан хүүхдийн тоглох орчин бүрдэнэ.

СӨБ ын орчны стандарт хангагдана.

Байгууллагын материаллаг бааз бэхжинэ.

Төслийн хүрэх үр дүн

1. Биеийн тамирын болон тоглоомын талбай стандартын дагуу тохижуулагдсан байна.
2. Хүүхэд өсч том болохдоо сурч мэдэх хүсэл эрмэлзэлтэй, бусадтай зохицон амьдрах чадвартай, бүтээлч сэтгэлгээтэй, сонголт хийж чаддаг, тохиолдох саад бэрхшээлийг даван туулдаг, тулгарсан асуудлаа шийдвэрлэдэг, өөрийн гэсэн байр суурьтай иргэн болж төлөвшихөд дэмжлэг үзүүлсэн байна.
3. Хүүхдүүдийн эрүүл мэнд, бие бялдар, хөгжил төлөвшилд эерэг өөрчлөлт гарч ахиц гарсан байна.
4. Хүүхдүүд сурсан, чаддаг болсондоо өөрөөрөө бахархах сэтгэлтэй болсон байна.
5. Энэхүү төслийг хэрэгжүүлснээр ирээдүй болсон хүүхэд багачуудын сэтгэл зүй, бие бялдар, оюун ухааныг хөгжүүлэх орчин нөхцөл бүрдэж цаашид байнга ашиглагдах боломж үүсч байна.




Төслийн үйл ажиллагаа

1. Төсөл хэрэгжүүлэх эрх үүсэхэд төсөлд тусгагдсан биеийн тамирын талбайн хэрэглэгдэхүүнийг худалдан авах
2. Биеийн тамирын талбайн хэрэглэгдэхүүнийг хүүхдийн аюулгүй, эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн байрлуулах
3. Биеийн тамирын талбайн хэрэглэгдэхүүнийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэн авах, цаашдын ашиглалт, хамгаалалт болон хариуцан ажиллах багшид болон жижүүрүүдэд хүлээлгэн өгөх
4. Биеийн тамирын талбайн хэрэглэгдэхүүний цаашдын ашиглалтанд хяналт тавин ажиллах

Төслийн хяналт үнэлгээ

1. Төслийн үйл ажиллагааны хяналт үнэлгээг төслийн хугацаанд 2 удаа хийж эцэг эх, олон нийтийн төлөөллөөр хянуулна.
2. Төслийн үйл ажиллагааны үр шимийг хүртэгчдээс болон эцэг эх асран хамгаалагчдаас санал хүсэлт авч дүнг нэгтгэнэ. Төслийн явцад хийгдэж буй үйл ажиллагаа бүрийн дараа төслийн багийн гишүүдийн хамтарсан уулзалт хийж үнэлгээ өгч ажиллана.
3. Төслийн ажлын хэсгээс төслийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан гаргаж олсон ололт, гаргасан алдаа түүний шалтгааныг тодорхойлж дүн шинжилгээ хийнэ.
4. Төслийн тайланг 2023 оны 04 сарын 20-ны дотор санхүүжүүлэгч байгууллагад явуулна.
5. Цэцэрлэгийн нийт хүүхдүүдийн эцэг эх, асран хамгаалагчдын санал хүсэлтийг санал асуулгаар авч төсөлд хяналт тавих

Тоглоомын жагсаалт

1	Хүүхдийн ком тоглоом UDC175-3		360*240*350 Шон ф76	КОМ	4,380,000	2	8,760,000
2	Хүүхдийн ком тоглоом UD 1008		350*230*300 Шон ф76	КОМ	3,480,000	2	6,960,000
3			650*300*220	КОМ	6,800,000	1	6,800,000
4	Эргэдэг тоглоом 14 суудалтай\		D120	Ш	950,000	2	1,900,000
5	Дүүжин даажин		280*40*55	Ш	1,200,000	2	2,400,000
6	Хүүхдийн ком тоглоом HD18-160C		600*430*310 Шон ф89	КОМ	8,680,000	1	8,680,000
7	Хүүхдийн ком тоглоом UD 162-1		520*300*360 Шон ф76	КОМ	4,880,000	1	4,880,000

8	Үсэрдэг тоглоом		Ө3.66м	ш	1,200,000	2	2,400,000
9	Түшлэгтэй сандал		150 см	ш	368,000	4	1,472,000
10	Түшлэггүй сандал		150 см	ш	220,000	2	440,000
11	Ангилдаг хогийн сав		68*40*100	ш	300,000	4	1,200,000
Нийт дүн							45,892,000

Тоглоомын нэр	Сэцэн тоглоомын дэлгүүр		Буман тоглоомын дэлгүүр		Оч тоглоомын дэлгүүр	
	Тоо ширхэг	1 бүрийн үнэ	Тоо ширхэг	1 бүрийн үнэ	Тоо ширхэг	1 бүрийн үнэ
Д						
1.	Олон үйлдэлт гулсуур	1ком	8500,0	1	7000,0	
2.	Эргэдэг тоглоом /6 суудалтай/	1	1000,0	1	1500,0	/4 суудалтай/
3.	8 төрөлт угсардаг тоглоом	1ком	2500,0			
4.	Дүүжин даажин			1	470,0	1
5.	Гэрлэн дохио	1багц	423,5			
6.	Ангилдаг хогийн сав			1	385,0	1/2ангилдаг/
7.	Авирдаг хадтай уул	1	3800,0			
8.	Үсэрдэг тоглоом					1
9.	Олон төрөлт авирдаг тоглоом /трамплин/					1
10.	12 хүүхдийн савлуур					1
11.	Хүүхдийн сагсны шийд			1	550,0	1
12.	Сандал			2ш	2x280	2
13.	Хөл бөмбөгийн хаалга	2	2x230,0			

Тоглоомын дүн:32748,5 НӨҮТ 3274,5 Нийт үнэ:36023,0

Бусад зардал:

	Хэмжих нэгж	Хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
14. Ногоон зүлэг	М3	122,4	46000	5630,4
15. Тоглоомын бэхэлгээ төмөр, боолт	кг	129	3500	451,5
16. Элс	М3	18.9283	18000	340,7
17. Хайрга	М3	155.001	22000	341.0
18. Цемент	тн	1,5	35000	1050,0
19. Цавуу	кг	36	8000	288,0
20. Электрод	кг	30	6500	195,0
21. Төмөр гадас	ш	15	1500	22,5
22. Хадаас 70x100	кг	5000	4	20,0
23. 1 толгойтой цэнэг хураагууртай гэрэлтүүлэгч, төмөр багана 3,0м	ш	2	580000	1160,0
Дүн	9499,1	НӨҮТ 949,9	10449.1	
Тээврийн зардал	3528.0			
Нийт дүн	50000,0			

Төсөл боловсруулсан: Эрхлэгч *Анжир* Э.Нарантуяа

